

InvesCore FI

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02-р сарын 10-ний өдөр

№ 25/08

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.21 дэх заалт, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 4,544,656,860 (дөрвөн тэрбум таван зуун дөчин дөрвөн сая зургаан зуун тавин зургаан мянга найман зуун жаран) төгрөгийн ногдол ашгийг Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай;
2. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаа бүрд ногдох хэмжээг 60 (жаран) төгрөгөөр тогтоосугай;
3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай;
4. Энэхүү тогтоолын 2-т заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК- аар дамжуулан 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Компанийн хувьцаа эзэмшигчдийн дансанд олгосугай;
5. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

